



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 22 өдөр

Дугаар А/БЧ

Хэрлэн сум

О.Болормаагийн сургалтын
төлбөрт дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 03 дугаар сарын 31 ний “Мэргэжилтэй ажилтан бэлтгэх, хүний нөөцийг бүрдүүлэх журам батлах тухай” 24 дүгээр тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 05-ны “Аймгийн 2024 оны төсөв батлах тухай” хорин гуравдугаар хуралдааны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Зөгийн үүр” арга хэмжээний хүрээнд “Мэргэжилтэй ажилтан бэлтгэх, хүний нөөцийг бүрдүүлэх журам”-ын хэрэгжилтийг хангах зорилгоор Хэрлэн сумын иргэн О.Болормаагийн сургалтын төлбөрт зориулж 1,650,000 (нэг сая зургаан зуун тавин мянган) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх “Зөгийн үүр” арга хэмжээний зардлаас олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ